



**БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

СИСТЕМД НЭВТРЭХ ЭРХ НЭЭХ ГАРЫН АВЛАГА

Шинэчилсэн огноо: 2016.01.27

2016 он

АГУУЛГА

1. СИСТЕМД НЭВТРЭХ ЭРХ НЭЭХ.....	3
1.1 СИСТЕМИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ	3
1.2 СИСТЕМД НЭВТРЭХ ЭРХ НЭЭХ ЗААВАРЧИЛГАА.....	3
2. НУУЦ ҮГ СОЛИХ, СИСТЕМЭЭС ГАРАХ ЗААВАРЧИЛГАА.....	9
2.1 НУУЦ ҮГ СОЛИХ ЗААВАРЧИЛГАА.....	9
2.2 СИСТЕМЭЭС ГАРАХ ЗААВАРЧИЛГАА	11
3. “НУУЦ ҮГЭЭ МАРТСАН ҮЕД ЮУ ХИЙХ ВЭ” ЗААВАРЧИЛГАА.....	12

1. СИСТЕМД НЭВТРЭХ ЭРХ НЭЭХ

1.1 СИСТЕМИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Тэтгэлэгт хүсэлт гаргагч нь цахим өргөдөл бөглөж, илгээхийн тулд эхлээд “Тэтгэлгийн удирдлага” системд нэвтрэх шаардлагатай. Системд нэвтрэхдээ системийн эрхийг ашиглан нэвтрэнэ. Иймээс хамгийн эхэнд системийн эрхийг нээх үйлдлийг хийх хэрэгтэй. Хэрэглэгч тэтгэлгийн вэб сайтын нүүр хуудсанд байрлах нэвтрэх хэсэгт хэрэглэгчийн нэр, нууц үгийг бичиж нэвтрэх товчийг дарснаар нэвтрэх орох боломжтой болно. Өөрөөр хэлбэл нэвтрэх нэр, нууц үгийг системийн эрх гэж ойлгоно.

1.2 СИСТЕМД НЭВТРЭХ ЭРХ НЭЭХ ЗААВАРЧИЛГАА

Энэ бүлэгт нэвтрэх эрх үүсгэж “Тэтгэлгийн удирдлага” системд нэвтрэх алхамчилсан зааврыг өгнө.


Эрх нээж, “Тэтгэлгийн удирдлага” системд нэвтрэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Тэтгэлгийн вэб сайтын нүүр хуудас руу орно.
2. Нүүр хуудсанд байрлах **Нэвтрэх** хэсэгт байрлах **бүртгүүлэх** товчийг дарна.
3. **Бүртгэл** цонхны талбаруудыг бөглөж **бүртгүүлэх** товчийг дарснаар системээс баталгаажуулах кодыг и-мэйл хаяг руу илгээнэ.
4. Бүртгүүлэх үедээ ашигласан и-мэйл хаягаар орж баталгаажуулах кодыг авна.(И-мэйлээс шалтгаалж баталгаажуулах код нь и-мэйлийн Spam, Junk, Bulk-ийн аль нэг руу орсон байх боломжтой шалгаж үзнэ үү.)
5. И-мэйл дээр байгаа **системийн эрхийг энэ линкээр орж идэвхжүүлнэ үү** гэсэн хэсгийн **линк** дээр дарж хэрэглэгчийн эрх баталгаажуулах цонх руу орно.
6. **Эрх баталгаажуулах** бүртгэлийн цонхны талбаруудыг бөглөж **баталгаажуулах** товчийг дарна.
7. Бүртгүүлсэн мэйл хаяг, нууц үгийг системийн нүүр хуудасны нэвтрэх хэсгийн хэрэглэгчийн нэр, нууц үг талбарт бичиж нэвтрэх товчийг дарж “Тэтгэлгийн удирдлага” системд нэвтрэнэ.

Алхамчилсан заавар:

Алхам1


Интернет хөтчийн домэйн хаягийн талбарт esis.edu.mn/grant гэж бичээд enter товч дарснаар сургалтын тэтгэлгийн дараах вэб сайт руу орно.



The screenshot displays the website interface for the Education Support Initiative System (ESIS). At the top left, there is a logo for the Mongolian State University of Education Sciences (МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАСГИЙН ХӨДӨӨ) and the text "СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГ". To the right are social media icons for Facebook, Twitter, YouTube, LinkedIn, and Google+. The main banner features a group of students looking at a book, with a red box highlighting a login form overlay. The form is titled "СИСТЕМД НЭВТРЭХ" and includes fields for a username and password, a "Намайг сана" (Remember me) checkbox, and "НЭВТРЭХ" (Login) and "БҮРТГҮҮЛЭХ" (Register) buttons. Below the banner is a navigation menu with links: "ҮНДСЭН СИСТЕМ", "МЭДЭЭЛЭЛ", "ГАРЫН АВЛАГА & ВИДЕО ХИЧЭЭЛ", "ЭРХ ЗҮЙН АКТ", and "ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ ХАРИУЛТ". The main content area contains three featured sections: 1. "ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛГЭЭР СУРАЛЦУУЛАХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ" (Information for application in the grant system), 2. "СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ГАДААДАД СУРАЛЦУУЛАХ ХӨТӨЛБӨР" (Opportunity for international study in the grant system), and 3. "СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ГАДААДАД МАГИСТРАНТУР, ДОКТОРАНТУРТ СУРАЛЦУУЛНА" (Opportunity for international study in the grant system for Master's and Doctoral degrees).


Алхам2

Нүүр хуудасны баруун дээд хэсэгт байрлах **Системд нэвтрэх** хэсгийн доорх зурагт харуулсан бүртгүүлэх товч дээр дарна.



Алхам3


Системд нэвтрэх хэсгийн **Бүртгүүлэх** товч дээр дарахад дараах дэд цонх руу шилжинэ.




1. Бүртгэл цонхны **Бүртгүүлэх и-мэйл оруулна уу** талбарт өөрийн үргэлж ашигладаг бодит и-мэйл хаягийг оруулж, **зураг дээрх текстийг оруулна уу** талбарт **бүртгэл** цонхонд байгаа тоо, тэмдэгтээс бүрдсэн текстийг оруулж **бүртгүүлэх** товчийг дарна.
2. Бүртгүүлсэн мэйл хаяг руу системээс баталгаажуулах код илгээгдэнэ.

Алхам 3

1. Өөрийн бүртгүүлсэн и-мэйл хаягаар орж баталгаажуулах кодыг авна. Ингэхдээ и-мэйлээс шалтгаалж баталгаажуулах код нь и-мэйлийн Spam, Junk, Bulk-ийн аль нэг руу орсон байх боломжтой тул шалгаж үзнэ үү. И-мэйл хаяг руу ороход баталгаажуулах код дараах байдалтай ирсэн байна.




2. **Хэрэглэгчийн баталгаажуулалт** гэсэн ирсэн и-мэйл дээр дарахад дэлгэрэнгүй мэдээлэл дараах загвартай байна.





Хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код хэсгээс кодыг авсны дараа **энэ линкээр** гэсэн дээр дарахад дараах цонх нээгдэнэ.


Алхам4


Баталгаажуулалт


Нууц үг 

Нууц үгийг давтаж оруулна уу. 

Баталгаажуулах код 




Зураг дээрх текстийг оруулна уу. 

Баталгаажуулах 

1. **Нууц үг, нууц үгийг давтаж оруулна уу** талбаруудад хэрэглэгч өөрөө нууц үгээ зохиож оруулна.
2. **Баталгаажуулах код** талбарт мэйл хаягаар ирсэн **эрх баталгаажуулах кодыг** бичнэ.
3. **Зураг дээрх текстийг оруулна уу** талбарт зураг дээр байгаа тоо, тэмдэгтийг оруулна.
4. Баталгаажуулалт цонхны баруун доод хэсэгт байрлах **баталгаажуулах** товчийг дарснаар таны системд нэвтрэх эрх нээгдэнэ.

Алхам5



1. Бүртгүүлэхэд ашигласан мэйл хаягийг **нэвтрэх нэр** талбарт оруулна.
2. Өөрийн бүртгүүлсэн нууц үгийг **нууц үг** талбарт оруулна.
3. **Нэвтрэх** товчийг дарснаар “Тэтгэлгийн удирдлага” системд нэвтэрч, өргөдөл бөглөж, илгээх боломжтой болно.

Жич: Системд нэвтэрсний дараа өргөдөл бөглөж илгээх болон “Тэтгэлгийн удирдлага” системийг ашиглах зааврыг нүүр хуудасны “**Гарын авлага**” хэсгийн “**Өргөдөл бөглөж, илгээх гарын авлага**”-ыг татаж авч үзнэ үү.

2. НУУЦ ҮГ СОЛИХ, СИСТЕМЭЭС ГАРАХ ЗААВАРЧИЛГАА

Энэ бүлэгт нэвтрэх нууц үг солих болон системээс гарах алхамчилсан зааврыг өгнө.

2.1 НУУЦ ҮГ СОЛИХ ЗААВАРЧИЛГАА

Нууц үгийг солихдоо эхлээд системд нэвтрэх шаардлагатай.


Нууц үгийг солихдоо дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Сургалтын тэтгэлгийн вэб сайтын нүүр хуудсанд байрлах **Нэвтрэх** хэсэгт нэвтрэх нэр, нууц үгийг бичиж нэвтрэх товчийг дарснаар тэтгэлгийн удирдлага системд нэвтрэнэ.
2. Системийн үндсэн цонхны баруун дээд хэсгээс **нууц үг солих** үйлдлийг дарж нууц үг солих дэд цонхны мэдээллийг бөглөж, хадгална.
3. **Системээс гарах** үйлдлээр системээс гарч шинэ нууц үгээр системд дахин нэвтрэнэ.

Алхамчилсан заавар:

Алхам1


Нүүр хуудасны баруун дээд хэсэгт байрлах системд нэвтрэх хэсэг нь доорх байдалтай байна.



1. Бүртгүүлэхэд ашигласан мэйл хаягийг **нэвтрэх нэр** талбарт оруулна.
2. Өөрийн бүртгүүлсэн нууц үгийг **нууц үг** талбарт оруулна.

Нэвтрэх товчийг дарснаар “Тэтгэлгийн удирдлага” системд нэвтэрч дараах цонх нээгдэнэ.

Алхам2



1. Тэтгэлгийн удирдлага системийн үндсэн цонхны баруун дээд хэсэгт байрлах хэрэглэгчийн нэрний ард байрлах **сум** дээр дарахад дээрх дэд цонх нээгдэнэ.
2. Дэд цонхны **нууц үг солих** гэсэн үйлдлийг дарахад дараах дэд цонх нээгдэнэ.

Алхам3


1. **Хуучин нууц үг** талбарт хуучин нууц үгийг бичнэ.
2. **Шинэ нууц үг** талбарт солих гэж байгаа шинэ нууц үгийг бичнэ.
3. **Баталгаажуулалт** талбарт шинэ нууц үгийг давтаж оруулна.
4. Дэд цонхны баруун доод хэсэгт байрлах **нууц үг солих** товчийг дарахад нууц үг солигдож хадгалагдана.

Системээс гараад дахин нэвтрэхдээ шинэ нууц үгийг ашиглана.

2.2 СИСТЕМЭЭС ГАРАХ ЗААВАРЧИЛГАА

Энэ бүлэгт системээс гарах үйлдлийг хэрхэн хийх тухай зааврыг өгнө.

Тэтгэлгийн удирдлагын системд нэвтэрсний дараа үндсэн цонх дараах байдалтай байна.



1. Тэтгэлгийн удирдлага системийн үндсэн цонхны баруун дээд хэсэгт байрлах хэрэглэгчийн нэрний ард байрлах **сум** дээр дарахад дээрх дэд цонх нээгдэнэ.
2. Дэд цонхны **системээс гарах** гэсэн үйлдлийг дарахад системээс гарч тэтгэлгийн вэб сайтын үндсэн хуудас руу шилжинэ.

Санамж: Та системээс гарахдаа дээрх зааврын дагуу гарч байна уу. Ингэснээр таны эрхээр хэн нэгэн орж мэдээллийг өөрчлөх эрсдлээс хамгаалагдана.

3. “НУУЦ ҮГЭЭ МАРТСАН ҮЕД ЮУ ХИЙХ ВЭ” ЗААВАРЧИЛГАА


Энэ бүлэгт нууц үгээ мартсан хэрэглэгч системд хэрхэн дахин нэвтрэх тухай зааврыг өгнө.

Мартсан нууц үгийг өөрчилж, сэргээхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Тэтгэлгийн сайтын нүүр хуудасны **системд нэвтрэх** хэсэгт байрлах **нууц үгээ мартсан** гэсэн үйлдэл дээр дарахад **бүртгэл** дэд цонх нээгдэнэ.
2. Дэд цонхны талбарыг бөглөөд **илгээх** товчийг дарахад **баталгаажуулах код** бүртгүүлсэн мэйл хаяг руу илгээгдэнэ.
3. Бүртгүүлсэн мэйл хаягаа шалгаж, баталгаажуулах кодыг авах бөгөөд хэрэглэгчийн нууц үгийг **энэ линкээр** орж солино уу гэсэн дээр дарахад дэд цонх нээгдэнэ.
4. Дэд цонхны мэдээллийг бөглөөд баталгаажуулах товчийг дарахад тухайн дэд цонхонд бөглөсөн нууц үгээр системд дахин нэвтрэх боломжтой болно.

Алхамчилсан заавар:

Алхам1



1. Тэтгэлгийн сайтын нүүр хуудасны **системд нэвтрэх** хэсэгт байрлах **нууц үгээ мартсан** гэсэн үйлдэл дээр дарахад дараах дэд цонх нээгдэнэ.

Алхам2

Бүртгэл

Бүртгүүлсэн e-mail оруулна уу.


m5ax0n

Зураг дээрх текстийг оруулна уу.

Буцах Илгээх

1. **Бүртгүүлсэн и-мэйл оруулна уу** талбарт системд нэвтрэх эрх нээлгэхдээ бүртгүүлсэн и-мэйл хаягийг бичнэ.
2. **Зураг дээрх текстийг оруулна уу** талбарт зураг дээрх тоо үсгээс бүрдсэн тэмдэгтийг бичнэ.
3. **Бүртгэл** цонхны баруун доод хэсэгт байрлах **илгээх** товчийг дарахад бүртгүүлсэн и-мэйл хаяг руу нууц үгийг солихдоо хэрэглэх **баталгаажуулах код** илгээгдэнэ.

Алхам3



1. Бүртгүүлсэн и-мэйл хаягийн Spam, Junk, Bulk (и-мэйл хаягийн төрлөөс шалтгаалж)-ийг шалгахад баталгаажуулах код дээрх байдалтай ирсэн байна. **Хэрэглэгчийн баталгаажуулалт** гэсэн мэдээллийн нэр дээр дарахад ирсэн мэдээллийн дэлгэрэнгүй нь дараах байдалтай байна.

Алхам4

Эрхэм хэрэглэгч таньд энэ өдрийн мэнд хүргэе.

Хэрэглэгчийн нууц үгийн баталгаажуулах код: **6i5dbc1lko**

Хэрэглэгчийн нууц үгийг [энэ линкээр](#) орж солино уу.

Вэб сайт: <http://www.esis.edu.mn/grant>

Холбоо барих: esis@mecs.gov.mn

1. Зурагт харуулсан тоо үсгээс бүрдсэн **баталгаажуулах код**-ыг дээрх мэдээллээс авах бөгөөд **хэрэглэгчийн нууц үгийг энэ линкээр орж солино уу** гэсэн өгүүлбэрийн **энэ линкээр** гэсэн үгэн дээр дарахад дараах дэд цонх нээгдэнэ.

Алхам5

Нууц үг солих

██████████@gmail.com

Шинэ нууц үг

Нууц үгийг давтаж оруулна уу.

Баталгаажуулах код

s6tzad

Зураг дээрх текстийг оруулна уу.

Өөрчлөх

1. **Шинэ нууц** үг талбарт шинээр нууц үг зохиож оруулна.
2. **Нууц үгийг давтаж оруулна уу** талбарт шинэ нууц үгээ дахин оруулна.
3. **Баталгаажуулах код** талбарт и-мэйлээр ирсэн **код**-ыг оруулна.
4. **Зураг дээрх текстийг оруулна уу** талбарт зураг дээрх тоо үсгээс бүрдсэн тэмдэгтийг оруулна.
5. Цонхны баруун доод хэсэгт байрлах **өөрчлөх** товчийг дарахад **өмнөх мартсан нууц** үг шинэ нууц үгээр солигдоно.

Шинээр үүсгэсэн нууц үгийг ашиглан системд дахин нэвтрэх боломжтой болно.